*Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны … сарын …-ны … тоот тушаалын … дугээр хавсралт*

**Тайлбар:**

Шинэ-Зеландын дүрмийн өөрчлөлтөөр нэмж орсон / ~~хассан~~

“ИНД-ийн нэр томьёоны тайлбар”-ын дагуу нэмж орсон / ~~хассан~~

Найруулга зассан

**Анхаар:**

Та баруун дээд буланд байгаа navigation bar-ийн “**Two page view**”-г сонгож монгол, англи хувилбарыг зэрэгцүүлэн харж болно.




# ИНД - 175

## Нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын гэрчилгээжүүлэлт

Иргэний нисэхийн ерөнхий газар

**Note:**

NZCAR Part-175 revised items: revised / ~~deleted~~

**Attention:**

Please select "**Two page view**" option on the top-right navigation bar to view the Mongolian and English versions of the rule side by side.




# PART 175

# Aeronautical Information Service Organisations - Certification

Civil Aviation Authority of Mongolia

## ДҮРМИЙН ТАЙЛБАР

Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

- ИНЕГ-ын өмнөөс Монгол Улсад Нисэхийн Мэдээллийн Үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны;
- Монгол Улсын Нисэхийн мэдээллийн эмхэтгэл (цаашид AIP гэх), Нисэхийн мэдээллийн цуврал (цаашид AIC гэх) болон NOTAM-ын.

**Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-175-ын цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-175, түүний нэмэлт өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.**

## DESCRIPTION

Part 175 prescribes-

- rules governing the certification and operation of organisations providing an aeronautical information service for Mongolia on behalf of the Authority; and
- the requirements for Aeronautical Information Publication Mongolia, Aeronautical Information Circulars and NOTAM.

**This document is the current consolidated version of Part 175 produced by the Civil Aviation Authority, and serves as a reference only. It is compiled from the official ordinary rules that have been signed into law by the Minister of Road and Transport. Copies of the official rule and amendments as signed by Minister may be obtained from the Civil Aviation Authority or may be downloaded from the official web site at: www.mcaa.gov.mn**

**Мэдээлэл**

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн дүрмийг боловсруулсан.

| **Өөрчлөлтийн дугаар** | **Хүчин төгөлдөр болсон огноо** |
|---|---|
| Анхны боловсруулалт | 2003 оны 06 сарын 05 |
| Нэмэлт өөрчлөлт 1 | 2007 оны 09 сарын 18 |
| Нэмэлт өөрчлөлт 2 | 2010 оны 03 сарын 22 |
| Нэмэлт өөрчлөлт 3 (Шинэчлэлт) | 2021 оны 02 сарын 04 |
| Нэмэлт өөрчлөлт 4 | 2022 оны … сарын … |

**Тэмдэглэл:** ИНД-175-ын шинэчлэлтийг монгол, англи хэл дээр, NZ Part 175-ын 2017 оны 03 сарын 10-ны A.8-д үндэслэн боловсруулсан болно.

**Bulletin**

ICAO 29th Assembly Resolution A29-3 of year 1992 urges States to promote global harmonization of national rules.

In order to implement this Resolution, Mongolian Civil Aviation Regulation has been developed based on “Memorandum for Technical Cooperation” between CAA of Mongolia and New Zealand, signed on 6th of May, 1999.

| **Amendment history** | **Effective Date** |
|---|---|
| Original issue | 05 June 2003 |
| Amendment 1 | 18 September 2007 |
| Amendment 2 | 22 March 2010 |
| Amendment 3 (Re-issue) | 04 February 2021 |
| Amendment 4 | … … 2022 |

**Note:** This Part 175 re-issue has been released in Mongolian and English languages, based on NZCAR Part 175 Amend.8 of 10 Mar 2017.

# Гарчиг


**А Бүлэг - Ерөнхий зүйл ..... 1**
175.1. Хамрах хүрээ ..... 1
175.3. Гэрчилгээний шаардлага ..... 1
175.5. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах ..... 1
175.7. Гэрчилгээ олгох ..... 1
175.9. Гэрчилгээ эзэмшигчийн эрх ..... 1
175.11. Гэрчилгээний хугацаа ..... 1
175.13. Гэрчилгээ сунгах ..... 2

**B Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага ..... 2**
175.51. Ажилтанд тавих шаардлага ..... 2
175.53. Байгууламжийн шаардлага ..... 3
175.55. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хамрах хүрээ ..... 3
175.57. Баримт бичиг ..... 3
175.59. Мэдээлэл цуглуулах ..... 4
175.61. Нисэхийн мэдээллийг хэвлэн нийтлэх ..... 4
175.63. Хэвлэн нийтэлсэн мэдээллийн алдааг залруулах ..... 6
175.65. Бүртгэл ..... 6
175.67. Аюулгүй байдлын удирдлага ..... 7
175.69. НМҮБ-ын Ерөнхий заавар ..... 7

**C Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага ..... 8**
175.101. Байнгын хэрэгжилт ..... 8
175.103. AIP-ын үйлчилгээ ..... 8
175.105. NOTAM-ын үйлчилгээ ..... 9
175.107. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ ..... 9
175.109. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт ..... 11

**D Бүлэг - Монгол Улсын AIP ..... 12**
175.151. Монгол Улсын AIP-ын агуулга ..... 12
175.153. Монгол Улсын AIP-ын тодорхойлолт ..... 12
175.155. AIP-ын Өөрчлөлтийн тодорхойлолт ..... 13
175.157. AIP-ын Нэмэлтийн тодорхойлолт ..... 13

**E Бүлэг - AIC ..... 14**
175.201. AIC-ын тодорхойлолт ..... 14

**F Бүлэг - NOTAM ..... 14**
175.251. NOTAM-ын тодорхойлолт ..... 14
175.253. NOTAM-ыг түгээх ..... 15

**G Бүлэг - Шилжилтийн зохицуулалт ..... 16**
175.301. НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн шилжилт ..... 16
175.303. НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн шилжилтийн дотоод чанар баталгаажуулалт ..... 17

## List of Rules

**Subpart A - General ........ 1**
175.1. Applicability ........ 1
175.3. Requirement for Certificate ........ 1
175.5. Application for Certificate ........ 1
175.7. Issue of Certificate ........ 1
175.9. Privileges of Certificate ........ 1
175.11. Duration of Certificate ........ 1
175.13. Renewal of Certificate ........ 2

**Subpart B - Certification Requirements ........ 2**
175.51. Personnel Requirements ........ 2
175.53. Facility Requirements ........ 3
175.55. Scope of Pre-flight Information Service ........ 3
175.57. Documentation ........ 3
175.59. Collection of Information ........ 4
175.61. Publication of aeronautical information ........ 4
175.63. Error Correction in Published Information ........ 6
175.65. Records ........ 6
175.67. Safety management ........ 7
175.69. Aeronautical information service organisation exposition ........ 7

**Subpart C - Operating Requirements ........ 8**
175.101. Continued Compliance ........ 8
175.103. AIP service ........ 8
175.105. NOTAM Service ........ 9
175.107. Pre-flight Information Service ........ 9
175.109. Changes to certificate holder's organisation ........ 11

**Subpart D - Aeronautical Information Publication Mongolia ........ 12**
175.151. Contents of AIP Mongolia ........ 12
175.153. Specifications for AIP Mongolia ........ 12
175.155. Specifications for AIP Amendments ........ 13
175.157. Specifications for AIP supplements ........ 13

**Subpart E - AIC ........ 14**
175.201. Specifications for an AIC ........ 14

**Subpart F - NOTAM ........ 14**
175.251. Specifications for NOTAM ........ 14
175.253. Distribution of NOTAM ........ 15

**Subpart G - Transition Provisions ........ 16**
175.301. Transition for aeronautical information service certificate holders ........ 16
175.303. Transitional internal quality assurance for aeronautical information service certificate holders ........ 17

# А Бүлэг - Ерөнхий зүйл

## 175.1. Хамрах хүрээ

Энэ Дүрэм нь дараах зохицуулалтын шаардлагыг тогтооно:

(1) Монгол Улсад ~~Нисэхийн Мэдээллийн Үйлчилгээ~~ НМҮ үзүүлдэг байгууллагын гэрчилгээжүүлэлтийн болон үйл ажиллагааны;

(2) Монгол Улсын AIP, AIC болон NOTAM-ын.

## 175.3. Гэрчилгээний шаардлага

Аливаа этгээд нь энэ Дүрмийн дагуу олгосон нисэхийн мэдээллийн үйлчилгээний байгууллагын (цаашид “НМҮБ” гэх) гэрчилгээний эрх болон нөхцөлд заагаагүй НМҮ-г Монгол Улсын FIR-д үзүүлэхгүй байх үүрэгтэй.

## 175.5. Гэрчилгээ эзэмших хүсэлт гаргах

НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь CAA 24175/01 маягтыг бөглөж, дараах баримтын хамт Даргад хүргүүлнэ:

(1) 175.69-д шаардсан Ерөнхий заавар;

(2) зохих төлбөрийн баримт.

## 175.7. Гэрчилгээ олгох

Хэрэв Дарга дараах шаардлага хангагдсан гэж үзвэл, ~~хүсэлт гаргагч нь~~ энэ Дүрмийн дагуу НМҮБ-ын гэрчилгээг Дарга олгож болно ~~эзэмших эрхтэй~~:

(1) хүсэлт гаргагч В Бүлгийн шаардлага хангасан байх;

(2) хүсэлт гаргагч болон 175.51(a)(1), (2)-т шаардсан хүсэлт гаргагчийн удирдах ажилтан, эсхүл ажилтнууд нь тохирох зөв хүн байх;

(3) тухайн гэрчилгээг олгох нь нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхолд харшлахгүй байх.

## 175.9. Гэрчилгээ эзэмшигчийн эрх

НМҮБ-ын гэрчилгээнд, тухайн гэрчилгээ эзэмшигчид зөвшөөрсөн НМҮ-г заана.

## 175.11. Гэрчилгээний хугацаа

(a) НМҮБ-ын гэрчилгээг 5 жил хүртэл хугацаагаар олгож, эсхүл сунгаж болно.

(b) НМҮБ-ын гэрчилгээ нь түүний хугацаа дууссан, түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосноос бусад тохиолдолд хүчинтэй хэвээр байна.

(c) НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээний хугацаа дууссан, эсхүл хүчингүй болсон тохиолдолд гэрчилгээг Даргад нэн даруй хураалгах үүрэгтэй ~~на~~.

(d) Гэрчилгээг түдгэлзүүлсэн тохиолдолд, НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь зохих баталгаажуулсан бичилт хийлгэхээр Даргад нэн даруй хүргүүлэх үүрэгтэй ~~нэ~~.

# Subpart A - General

## 175.1. Applicability

This Part prescribes-

(1) rules governing the certification and operation of organisations providing an aeronautical information service for Mongolia; and

(2) the requirements for the Aeronautical Information Publication Mongolia, Aeronautical Information Circulars and NOTAM.

## 175.3. Requirement for certificate

~~No~~ A person ~~shall~~ must not provide an aeronautical information service for the Mongolian FIR except under the authority of~~, and in accordance with the provisions of,~~ an aeronautical information service certificate issued under this Part.

## 175.5. Application for certificate

~~Each~~ An applicant for the grant of an aeronautical information service certificate shall complete form CAA 24175/01 and submit it to the Director with-

(1) the exposition required by rule 175.69; and

(2) a payment of the appropriate application fee.

## 175.7. Issue of certificate

An ~~applicant is entitled to~~ an aeronautical information service certificate may be issued by the Director under this Part if the Director is satisfied that-

(1) the applicant meets the requirements of Subpart B; and

(2) the applicant, and the applicant's senior person or persons required by rules 175.51(a)(1) and (2) are fit and proper persons; and

(3) the granting of the certificate is not contrary to the interests of aviation safety.

## 175.9. Privileges of certificate

The aeronautical information service certificate specifies the aeronautical information services that the certificate holder is authorised to provide.

## 175.11. Duration of certificate

(a) An aeronautical information service certificate may be granted or renewed for a period of up to 5 years.

(b) An aeronautical information service certificate remains in force until it expires or is suspended or revoked.

(c) The holder of an aeronautical information service certificate that expires or is revoked ~~shall forthwith~~ must surrender the certificate to the Director.

(d) The holder of an aeronautical information service certificate that is suspended, ~~shall forthwith~~ must produce the certificate to the Director for appropriate endorsement.

### 175.13. Гэрчилгээ сунгах

(a) НМҮБ-ын гэрчилгээ сунгуулах хүсэлтийг CAA 24175/01 маягтын дагуу гаргах ёстой.

(b) Хүсэлтийг тухайн гэрчилгээнд заасан сунгах хугацаанаас өмнө, эсхүл хэрэв сунгах хугацаа заагаагүй бол гэрчилгээний хугацаа дуусахаас 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.

## B Бүлэг - Гэрчилгээжүүлэлтийн шаардлага

### 175.51. Ажилтанд тавих шаардлага

(a) НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажилтныг үндсэн ажилтнаар, эсхүл гэрээгээр ажиллуулах үүрэгтэй:

- (1) хүсэлт гаргагчийн Ерөнхий заавdefinition заасан НМҮ бүрийг дараах байдлаар гүйцэтгэхээ тухайн байгууллагын хүрээнд батлах үүрэгтэй, Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон удирдах ажилтан:
  - (i) үйл ажиллагааны шаардлагад нийцүүлэн санхүүжүүлж чаддаг байх;
  - (ii) энэ Дүрэмд заасан шаардлагын дагуу үзүүлдэг байх;
- (2) дараах үйл ажиллагааны чиглэлээр Гүйцэтгэх захирлын өмнө эцсийн хариуцлага хүлээх удирдах ажилтан, эсхүл ажилтнууд:
  - (i) тухайн байгууллага нь Ерөнхий заавартаа нийцэж байгааг батлах;
  - (ii) 175.67-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо;
- (3) Ерөнхий заавартаа заасан НМҮ-нд зориулсан нисэхийн мэдээллийг цуглуулах, эмхлэх, шалгах, зохицуулах, боловсруулах болон хэвлэн нийтлэх хангалттай тооны ажилтан.

(aa)Энэ зүйлийн (a)(2)(ii)-т шаардсан удирдах ажилтан нь гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа болон аюулгүй байдлын удирдлагын тогтолцоотой холбоотой ур чадвар, туршлагаа харуулсан байх үүрэгтэй.

(b) Хүсэлт гаргагч нь дараах үүрэгтэй:

- (1) Ерөнхий заавартаа заасан НМҮ-нд зориулсан нисэхийн мэдээллийг шалгах, боловсруулах болон хэвлэх зорилгоор хүсэлт гаргагчийн эрх олгосон ажилтны ур чадварын анхны үнэлгээг хийх журмыг тогтоох;
- (2) эрх бүхий ажилтны ур чадварыг хадгалах журмыг тогтоох;
- (3) эрх бүхий ажилтанд, түүний эрхийн хүрээг тодорхойлсон нотлох баримтыг бичгээр олгох.

### 175.13. Renewal of Certificate

(a) An application for the renewal of an aeronautical information service certificate must be made on form CAA 24175/01.

(b) The application must be submitted to the Director before the application renewal date specified on the certificate or, if no such date is specified, not less than 30 days before the certificate expires.

## Subpart B - Certification Requirements

### 175.51. Personnel requirements

(a) An applicant for the grant of an aeronautical information service certificate must employ, or contract-

- (1) a senior person identified as the chief executive who has the authority within the organisation to ensure that every aeronautical information service listed in the applicant's exposition-
  - (i) can be financed and is provided to meet operational requirements; and
  - (ii) is provided ~~in accordance with the requirements~~ as prescribed by this Part; and
- (2) a senior person or persons ultimately responsible to the chief executive who are responsible for-
  - (i) ensuring that the organisation complies with its exposition; and
  - (ii) the system for safety management required under rule 175.67; and
- (3) sufficient personnel to collect, collate, check, coordinate, edit, and publish aeronautical information for the aeronautical information services listed in the applicant's exposition.

(aa) The senior person required by paragraph (a)(2)(ii) must be able to demonstrate competency and experience relevant to the management of safety systems and the activities of the certificate holder.

(b) The applicant must-

- (1) establish a procedure for initially assessing the competence of personnel authorised by the applicant to check, edit, and publish aeronautical information for the aeronautical information services listed in the exposition; and
- (2) establish a procedure ~~to~~ for maintaining the competence of those authorised personnel; and
- (3) provide those authorised personnel with written evidence of the scope of their authorisation.

## 175.53. Байгууламжийн шаардлага

НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах ажлын байр болон байгууламжтай байх үүрэгтэй на:

(1) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт~~аа~~ заасан НМҮ-нд тохирсон;

(2) 175.103(b) болон 175.105-ын холбогдох шаардлагыг хангасан.

## 175.55. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хамрах хүрээ

Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа заасан нислэгийн өмнөх үйлчилгээнд зориулж дараах бүс, замыг заах үүрэгтэй ~~на~~:

(1) газар зүйн бүс;

(2) аэродром болон тухайн аэродромоос эхлэлтэй агаарын зам.

## 175.57. Баримт бичиг

(a) НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд хэвлэн нийтэлдэг нисэхийн мэдээллийн формат болон стандартыг тогтоох;

(2) тухайн формат болон стандарт нь мэдээллийг ашиглах нөхцөл байдлыг тооцон үздэг болохыг бататгах;

(3) Ерөнхий заавартаа заасан НМҮ-нд шаардлагатай холбогдох ишлэл ~~лавлагааны~~ материал, стандарт, зөвлөмж, журам болон бусад ~~холбогдох~~ баримт бичгийн хувийг хадгалдаг байх.

(b) Хүсэлт гаргагч нь дараах шаардлагыг бататгах зорилгоор энэ зүйлийн (a)-д шаардсан бүх баримт бичгийг хянах журмыг тогтоосон байна:

(1) баримт бичгийг боловсруулж гаргахаас өмнө холбогдох ажилтан хянаж, зөвшөөрдөг байх;

(2) Ерөнхий заавартаа заасан НМҮ-нд ашиглахад шаардлагатай холбогдох баримт бичгийн хүчинтэй хувийг, тухайн баримт бичиг шаардлагатай бүх байрлалд ажилтан авч ашиглахад бэлэн байлгах;

(3) хүчингүй болсон баримт бичгийг боловсруулж гаргасан, эсхүл ашиглаж байгаа цэг бүрээс нэн даруй хураан авдаг байх;

(4) баримт бичигт орсон өөрчлөлтийг холбогдох ажилтан хянаж, бататгадаг байх;

(5) хугацаа нь дууссан хэвлэлтийг ашиглахаас сэргийлж баримт бичгийн хуудас бүрийн хүчинтэй хувилбарыг таньж тогтоож болдог байх.

## 175.53. Facility requirements

~~Each~~ An applicant for the grant of an aeronautical information service certificate ~~shall~~ must establish offices and facilities that-

(1) are appropriate for the aeronautical information services listed in ~~their~~ the applicant's exposition; and

(2) meet the applicable requirements of 175.103(b) and 175.105.

## 175.55. Scope of pre-flight information service

~~Each~~ An applicant for the grant of an aeronautical information service certificate for a pre-flight information service ~~shall~~ must, for the pre-flight services listed in ~~their~~ the applicant's exposition, specify-

(1) the geographic area; and

(2) the aerodromes and the air routes originating from those aerodromes.

## 175.57. Documentation

(a) Each applicant for the grant of an aeronautical information service certificate shall-

(1) document the format and standards for the aeronautical information published under the authority of their certificate; and

(2) ensure that the format and standards take into account the circumstances under which the information will be used; and

(3) hold copies of relevant reference material, standards, practices and procedures, and any other documentation that is necessary for the aeronautical information services listed in their exposition.

(b) The applicant shall establish a procedure to control all the documentation required by paragraph (a), to ensure that-

(1) the documentation is reviewed and authorised by appropriate personnel before issue; and

(2) current issues of relevant documentation are available to staff at all locations where they need access to such documentation for the aeronautical information services listed in their exposition; and

(3) all obsolete documentation is promptly removed from all points of issue or use; and

(4) changes to documentation are reviewed and approved by appropriate personnel; and

(5) the current version of each item of documentation can be identified to preclude the use of out-of-date editions.

### 175.59. Мэдээлэл цуглуулах

(a) НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа заасан НМҮ-нд шаардлагатай мэдээллийг цуглуулах болон эмхлэх журмыг тогтоосон байх үүрэгтэй на.

(b) Энэ зүйлийн (a)-д заасан журам Хүсэлт гаргагч нь дараах шаардлага хангасан журамтай болохоо батагтах үүрэгтэй сан байна:

(1) холбогдох мэдээллийг Монгол Улсын агаарын навигацийн системийг дэмжих үйлчилгээ үзүүлдэг байгууллагаас авдаг байх;

(2) Монгол Улсаас эхлэлтэй олон улсын агаарын замд нислэг үйлдэж байгаа, олон улсад ын агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчийн шаардлагад хамаарах, холбогдох мэдээллийг бусад Улсын НМҮБ-аас авдаг байх;

(3) цаг тухайд нь мэдээллээр хангах зохицуулалтыг энэ зүйлийн (b)(1) болон (2)-т заасан мэдээлэгч байгууллагатай хамтран хийдэг байх;

(4) энэ зүйлийн (b)(1)-д заасан мэдээлэгч байгууллагаас хүлээн авсан мэдээллийг тухайн мэдээллийн нарийвчлалыг хариуцсан мэдээлэгч байгууллагын томилсон этгээд үнэн зөв болохыг баталгаажуулдаг байх.

(c) Энэ зүйлийн (b)-д зааснаас гадна, NOTAM үйлчилгээний журам нь NOTAM гаргах мэдээлэгч байгууллагын хүсэлтээр тухайн NOTAM-ыг 3 сараас дээш хүчинтэй байхыг шаарддаггүй болохыг хүсэлт гаргагч батагтах үүрэгтэй.

### 175.61. Нисэхийн мэдээллийг хэвлэн нийтлэх

(a) НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа заасан үйлчилгээнд ашиглах нисэхийн мэдээллийг шалгах, зохицуулалт хийх, боловсруулах, хэвлэн нийтлэх болон түгээх журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(b) Хүсэлт гаргагч нь энэ зүйлийн (a)-ийн дагуу тогтоосон журамд дараах шаардлагыг заасан болохыг батагтах үүрэгтэй:

(1) 175.59-д заасны дагуу хүлээн авсан мэдээллийг хэвлэн нийтлэхийн өмнө боломжит мэдээлэл ашиглан түүний үнэн зөвийг батагтан, шалгадаг байх;

(2) 175.59-д заасны дагуу хүлээн авсан мэдээллийг дараах хэлбэрээр боловсруулдаг, үнэн зөв хэвлэн нийтэлдэг болон түгээдэг байх:

(i) тухайн мэдээллийн үйл ажиллагааны ач холбогдолд тохирсон форматаар;

(ii) хамааралтай бол D, E, эсхүл F Бүлгийн дагуу;

(iii) тухайн мэдээллийг ашиглах нөхцөл байдлыг тооцон үзсэн форматаар.

(3) энэ зүйлийн (b)(4)-т зааснаас бусад тохиолдолд, байнгын шинж чанартай нийтлэл хэвлэл болон урт хугацаатай, түр нийтлэл хэвлэлийг тухайн хүсэлт гаргагчийн НМҮБ-ын гэрчилгээний эрхийн хүрээнд хэвлэн нийтэлсэн болох нь тодорхой танигддаг байх;

(4) хэрэв 175.59(b)(2)-ын дагуу бусад Улсын НМҮБ-аас авсан нисэхийн мэдээллийг түгээдэг бол, тухайн мэдээллийг гаргадаг Улсын эрх бүхий байгууллагаас хүлээн авсан болохыг тодорхой таньж тогтоодог байх;

## 175.59. Collection of information

(a) ~~Each~~ An applicant for the grant of an aeronautical information service certificate ~~shall~~ must establish procedures ~~to~~ for collecting and collating ~~e~~ the information required for the aeronautical information services listed in ~~their~~ the applicant's exposition.

(b) The ~~procedures specified in paragraph (a) shall~~ applicant must ensure that the procedures provide for the following-

(1) applicable information is obtained from organisations that provide services in support of the Mongolian air navigation system; and

(2) applicable information is obtained from the aeronautical information services of other States relevant to the requirements of international aircraft operators operating on international air routes originating from Mongolia; and

(3) arrangements for the timely provision of information are made with the information originators prescribed in paragraphs (b)(1) and (2); and

(4) information received from the information originators prescribed in paragraph (b)(1) is certified as accurate by a person identified by the originator to be responsible for the accuracy of that information.

(c) The applicant must ensure that the procedures for the NOTAM service must, in addition to paragraph (b), provide that the originator's request for the issue of a NOTAM does not require the NOTAM to be effective for more than 3 months.

## 175.61. Publication of aeronautical information

(a) An applicant for the grant of an aeronautical information service certificate must establish procedures for checking, co-ordinating, editing, publishing and disseminating aeronautical information for the services listed in the applicant's exposition.

(b) The applicant must ensure that the procedures established under paragraph (a) provide for the following-

(1) the information received under rule 175.59 to be checked against available information is verified as accurate before its publication; and

(2) the information received under rule 175.59 to be edited, accurately published, and disseminated-

(i) in the format applicable to the operational significance of the information; and

(ii) if applicable, in accordance with subparts D, E, or F; and

(iii) is in a format that takes account of the circumstances under which the information is to be used; and

(3) except for paragraph (b)(4), permanent publications and long-term temporary publications to be clearly identified as being published under the authority of the applicant's aeronautical information service certificate; and

(4) if aeronautical information obtained from the aeronautical information services of other States under rule 175.59(b)(2) is disseminated, that information to be clearly identified as having the authority of the originating State; and

(5) хэрэв 175.59(b)(4)-т заасны дагуу үнэн зөвийг баталгаажуулаагүй мэдээллийг түгээдэг бол, тухайн мэдээллийг баталгаажуулаагүй болохыг тодорхой таньж тогтоодог байх ёстой;

(6) хэвлэн нийтэлсэн мэдээлэлд байнгын шинж чанартай өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн өөрчлөлтийг хэвлэн нийтлэхийн өмнө холбогдох бусад мэдээлэгч байгууллагатай хамтран зохицуулалт хийдэг байх;

(7) мэдээлэгч байгууллагаас тухайн мэдээллийг цуцлах, эсхүл дахин гаргахыг шаардсан арга хэмжээ авдаг болохыг бататгах зорилгоор тогтоосон дуусах хугацаагүй хэвлэн нийтэлсэн түр мэдээллийг тодорхой хугацаанд хянадаг байх;

(8) нисэхийн мэдээллийг ашиглах хэлбэрээс шалтгаалан англи хэл / монгол хэл дээр хэвлэн нийтэлдэг байх;

(9) газар орны нэрийг орон нутгийн хэллэгийн дагуу үсэглэн бичих шаардлагатай тохиолдолд латин үсгээр галиглан бичих;

(10) хэмжлийн нэгж нь ИНД-91.4-т заасантай нийцсэн байх;

(11) хэвлэн нийтэлсэн нисэхийн мэдээлэлд, ~~ИНД~~ Annex-ийн нэр томьёоны тайлбарт нийцсэн товчлолыг хэрэглэдэг байх, хэрэв:

(i) хэрэглээ нь тохирч байгаа бол;

(ii) хэрэглээ нь мэдээллийн түгээлтийг хялбаршуулж байгаа бол;

(12) бусад Улсын НМҮБ-аас хүсэлт гаргасан тохиолдолд, хэвлэн нийтэлсэн аливаа нисэхийн мэдээллийг нэн даруй дамжуулдаг байх;

(13) нисэхийн мэдээллийг, дараах хэрэглэгчийн үйл ажиллагааны шаардлагад тохирох хэлбэрээр ашиглахад бэлэн байлгах:

(i) нисэх багийн гишүүд болон нислэгийн өмнөх ~~мэдээллийн~~ зааварчилгааны үйлчилгээг багтаасан нислэгийн үйл ажиллагааны ажилтнууд;

(ii) ~~НМҮ~~ нислэгийн мэдээллийн үйлчилгээ хариуцсан НХҮ-ний нэгж.

(c) Хүсэлт гаргагч нь AIP-ын үйлчилгээний журамд энэ зүйлийн (b)-д зааснаас гадна дараах шаардлага багтсан болохыг бататгах үүрэгтэй:

(1) нислэгийн зураг, AIP-ын Өөрчлөлт болон AIP-ын Нэмэлтэд хэвлэн нийтэлсэн үйл ажиллагааны чухал ач холбогдолтой мэдээллийг AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтэлдэг байх;

(2) AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтлэх мэдээлэл нь “AIRAC” товчлолыг тодорхой харуулдаг байх;

(3) AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтэлсэн мэдээллийг, тухайн мэдээлэл хүчинтэй болохоос 28-аас доошгүй хоногийн өмнө хэрэглэгч хүлээн авсан байхаар түгээдэг байх;

(4) AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтэлсэн мэдээллийг тухайн хүчинтэй өдрөөс хойш 28-аас доошгүй хоногт, мэдэгдсэн нөхцөл байдал нь түр зуурын шинж чанартай ба бүхий л цаг хугацааны турш нөлөөлөхгүй байхаас бусад тохиолдолд өөрчилдөггүй байх;

(5) хэрэв AIP-ын Нэмэлт нь NOTAM-ыг солих зорилгоор хэвлэн нийтлэгдсэн бол, тухайн Нэмэлт нь NOTAM-ын серийн дугаарын ~~лавлагааг~~ ишлэлийг багтаадаг байх;

(5) if information that has not been certified as accurate under rule 175.59(b)(4) is disseminated, that information must be clearly identified as unverified; and

(6) any permanent change to published information to be coordinated with other applicable information originators before the change is published; and

(7) temporary information that is published without a defined expiry date to be reviewed at an appropriate time to ensure that the originator takes the required action to cancel or reissue the information; and

(8) the aeronautical information to be published in the English/Mongolian language as necessary; and

(9) place names to be spelt according to local usage, transliterated when necessary into the Latin alphabet; and

(10) units of measurement to be consistent with those prescribed in rule 91.4; and

(11) abbreviations, consistent with those prescribed in CAR interpretation summary, to be used in the published aeronautical information if-
   (i) their use is appropriate; and
   (ii) their use facilitates the dissemination of the information; and

(12) any of the aeronautical information published to be promptly made available to the aeronautical information services of other States, upon request by those States; and

(13) the aeronautical information to be made available in a form that is suitable for the operational requirements of-
   (i) flight operations personnel, including flight crew members and the services responsible for pre-flight briefing; and
   (ii) the air traffic service units responsible for flight information services.

(c) The applicant must ensure that the procedures for the AIP service, in addition to paragraph (b), require-

(1) aeronautical charts, and operationally significant information published in AIP Amendments and AIP Supplements, to be published in accordance with the AIRAC system; and

(2) the information published under the AIRAC system to be clearly identified with the acronym AIRAC; and

(3) the information published under the AIRAC system to be distributed so that recipients receive the information at least 28 days before its effective date; and

(4) the information published under the AIRAC system to not change for at least 28 days after the effective date, unless the circumstance notified is of a temporary nature and would not persist for the full period; and

(5) if an AIP Supplement is published to replace a NOTAM, the supplement to include a reference to the serial number of the NOTAM; and

(6) хэрэв AIP-ын Өөрчлөлт, эсхүл AIP-ын Нэмэлтийг AIRAC тогтолцооны дагуу хэвлэн нийтэлсэн бол, гарах NOTAM нь үйл ажиллагааны чухал ач холбогдолтой агуулга, хүчинтэй болох өдөр болон өөрчлөлт, эсхүл нэмэлт бүрийн ~~лавлагааны~~ ишлэлийн дугаарын товч тайлбарыг өгдөг байх. NOTAM нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
   (i) тухайн өөрчлөлт, эсхүл нэмэлттэй нэг өдөр хүчинтэй болдог байх;
   (ii) 14 хоногийн хугацаанд хүчинтэй хэвээр байх;

(7) хэрэв AIRAC-ын хугацаанд хэвлэн нийтлэх холбогдох мэдээлэл байхгүй бол NIL гэсэн тэмдэглэгээг хэрэглэдэг ~~тэй нийтэлдэг~~ байх;

(8) хэрэв AIP-ын Өөрчлөлт, эсхүл AIP-ын Нэмэлтээр хэвлэн нийтлэх мэдээлэл нь тухайн Өөрчлөлт, эсхүл Нэмэлт хүчинтэй болох өдрөөс өмнө хүчинтэй болох бол NOTAM гаргадаг байх.

## 175.63. Хэвлэн нийтэлсэн мэдээллийн алдааг залруулах

(a) НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь тухайн гэрчилгээний эрхийн хүрээнд хэвлэн нийтэлсэн нисэхийн мэдээлэлд илэрсэн аливаа алдааг бүртгэх, шинжлэн шалгах, залруулах болон мэдээлэх журмыг тогтоосон байх үүрэгтэй ~~на~~.

(b) ~~Энэ зүйлийн (а)-д заасан журам~~ Хүсэлт гаргагч нь дараах шаардлага хангасан журамтай болохоо бататгах үүрэгтэй ~~сан байна~~:

(1) тухайн алдааны үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөнөөс хамаарч хамгийн тохиромжтой хэлбэрээр залруулдаг байх;

(2) дахин хэвлэн нийтэлсэн мэдээллийн залруулга нь тодорхой таньж тогтоогддог байх;

(3) алдааны эх сурвалжийг таньж тогтоодог байх ба боломжтой бол түүнийг устгадаг байх;

(4) түгээгдсэн мэдээллийн зөрчлийг ИНД-12-ын дагуу Даргад мэдээлдэг байх.

## 175.65. Бүртгэл

(a) НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь Ерөнхий заавартаа заасан НМҮ-нд шаардлагатай бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, хөтлөх болон устгах журмыг тогтоосон байх үүрэгтэй.

(b) Энэ зүйлийн (а)-д заасан журам нь дараах шаардлагыг бататгасан байх ёстой:

(1) хүлээн авсан болон түгээсэн бүх нисэхийн мэдээллийг ~~дэс~~ серийн дугаар болон хугацаагаар нь хялбар таньж тогтоох боломжтой бүртгэлтэй байх, нэмэлт мэдээллийг ижил төстэй байдлаар бататгадаг байх ба шаардлагатай тохиолдолд таньж тогтоодог байх;

(2) хүсэлт гаргагчийн, нисэхийн мэдээллийг шалгах, боловсруулах болон хэвлэн нийтлэх эрх олгосон ажилтан бүрийн бүртгэлтэй байх;

(3) 175.63-т шаардсан журмын дагуу алдааг залруулсан тохиолдол бүрийн бүртгэлтэй байх;

(4) [*хүчингүй*]

(5) бүх бүртгэл нь гаргацтай бөгөөд байнгын арилдаггүй хэлбэртэй байх;

(6) if an AIP Amendment or AIP Supplement is published under the AIRAC system, a NOTAM to be originated giving a brief description of the operationally significant contents, the effective date and the reference number of each amendment or supplement. The NOTAM must-
   (i) come into force on the same effective date as the amendment or supplement; and
   (ii) remain in force for a period of 14 days; and

(7) if there is no applicable information to be published by the AIRAC date, a NIL notification to be issued; and

(8) a NOTAM to be originated if information to be published as an AIP Amendment or AIP Supplement takes effect prior to the effective date of the amendment or supplement.

## 175.63. Error correction in published information

(a) ~~Each~~ An applicant for the grant of an aeronautical information service certificate ~~shall~~ must establish procedures ~~to~~ for recording, investigating ~~e~~, correcting, and reporting any errors that are detected in the aeronautical information published under the authority of their certificate.

(b) The ~~procedures specified in paragraph (a) shall~~ applicant must ensure that the procedures provide for the following-

(1) the error is corrected by the most appropriate means relative to the operational significance of the error; and

(2) the correction is clearly identified in the republished information; and

(3) the source of the error is identified and, where possible, eliminated; and

(4) the Director is notified of a promulgated information incident ~~in accordance with~~ as required by Part 12.

## 175.65. Records

(a) An applicant for the grant of an aeronautical information service certificate must establish procedures to identify, collect, index, store, maintain and dispose of the records that are necessary for the aeronautical information services listed in their exposition.

(b) The procedures specified in paragraph (a) must ensure that-

(1) there are records enabling all incoming and outgoing aeronautical information to be readily identified by serial number and date, and that supplementary information can be similarly verified and, where necessary, authenticated; and

(2) there is a record of each person who is authorised by the applicant to check, edit, and publish aeronautical information; and

(3) there is a record of each occurrence of error correction under the procedures required by rule 175.63; and

(4) [*revoked*]

(5) all records are legible and of a permanent nature; and

(6) NOTAM, AIP-ын Нэмэлт болон AIC-ыг цуцалснаас хойш 30 хоног, бусад бүх бүртгэлийг 5 жилээс доошгүй хугацаагаар хадгалдаг байх.

## 175.67. Аюулгүй байдлын удирдлага

НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь ИНД-100.3-ын дагуу аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх болон үйл ажиллагаандаа мөрддөг байх үүрэгтэй.

## 175.69. НМҮБ-ын Ерөнхий заавар

(a) НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь дараах журмыг багтаасан Ерөнхий заавсрыг Даргад хүргүүлэх үүрэгтэй:

(1) Ерөнхий заавар болон түүнд багтсан бусад заавар нь дараах шаардлагыг хангасан болохыг бататган, хүсэлт гаргагчийн байгууллагын нэрийн өмнөөс Гүйцэтгэх захирал гарын үсэг зурсан мэдэгдэл:
  (i) тухайн байгууллагыг тодорхойлох ба энэ Дүрмийн байнгын хэрэгжилтийг бататгах хэлбэр болон аргыг харуулах;
  (ii) хүсэлт гаргагчийн байгууллагын ажилтнууд түүнийг байнга дагаж мөрддөг байх;

(1A) 175.67-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хувьд:
  (i) ИНД-100.3(b)-д шаардсан бүх баримт бичиг;
  (ii) НМҮБ-ын гэрчилгээ сунгуулах хүсэлт гаргаагүй хүсэлт гаргагчийн хувьд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэхийг дүрслэн харуулсан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө;

(2) 175.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын албан тушаал, нэр;

(3) 175.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын дараах үүрэг хариуцлагыг:
  (i) тухайн байгууллагын нэрийн өмнөөс Дарга, эсхүл ИНЕГ-тай шууд харьцах тэдний хариуцсан асуудал;
  (ii) аюулгүй байдлын удирдлагын үүрэг хариуцлага;

(4) 175.51(a)(1) болон (2)-т шаардсан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын хариуцлагын шугаман хамаарлыг харуулсан байгууллагын бүтцийн зураг;

(5) энэ зүйлийн (a)(6)-д заасан НМҮ-г үзүүлэх ажилтнуудын бүтцийн дэлгэрэнгүй мэдээлэл;

(5A) байгууллагын хүрээнд аюулгүй байдлын хариуцлагын шугаман хамаарлыг тодорхойлсон мэдээлэл;

(6) гэрчилгээний дагуу үзүүлэх НМҮ-ний жагсаалт;

(7) нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээний хувьд, 175.55-д шаардсан газарзүйн бүс, аэродром болон агаарын замын дэлгэрэнгүй мэдээлэл;

(8) 175.103(b)(1) болон 175.105(1)-д шаардсан нэгжийн байршил болон хаягийн дэлгэрэнгүй мэдээлэл;

(6) all records are retained for at least 5 years except NOTAM, AIP Supplements and Aeronautical Information Circulars, which need only be retained for 30 days after cancellation.

### 175.67. Safety management

An applicant for the grant of an aeronautical information service certificate must establish, implement, and maintain a system for safety management in accordance with rule 100.3.

### 175.69. Aeronautical information service organisation exposition

(a) An applicant for the grant of an aeronautical information service certificate must provide the Director with an exposition that contains-

- (1) a statement signed by the chief executive on behalf of the applicant's organisation confirming that the exposition and any included manuals-
  - (i) define the organisation and demonstrate its means and methods for ensuring ongoing compliance with the this Part; and
  - (ii) are to be complied with by the applicant's organisation's personnel at all times; and
- (1A) in relation to the system for safety management required by rule 175.67,-
  - (i) all of the documentation required by rule 100.3(b); and
  - (ii) for an applicant that is not applying for a renewal of an information aeronautical service certificate, an implementation plan that describes how the system for safety management will be implemented; and
- (2) the titles and names of the senior person or persons required by rules 175.51(a)(1) and (2); and
- (3) the duties and responsibilities of the senior person or persons required by rules 175.51(a)(1) and (2) including-
  - (i) matters for which they have responsibility to deal directly with the Director or the Authority on behalf of the organisation; and
  - (ii) responsibilities for safety management; and
- (4) an organisation chart showing lines of responsibility of the senior person or persons referred to in rules 175.51(a)(1) and (2); and
- (5) a summary of the staffing structure for each aeronautical information service listed under paragraph (a)(6); and
- (5A) information identifying the lines of safety responsibility within the organisation; and
- (6) a list of the aeronautical information services to be covered by the certificate; and
- (7) for a pre-flight information service, details of the area, aerodromes and air routes required by rule 175.55; and
- (8) the location and address details of the applicable offices required by rules 175.103(b)(1) and 175.105(1); and

(9) хэвлэн нийтэлсэн нисэхийн мэдээллийн хувьд, 175.57(a)(1)-д шаардсан хүсэлт гаргагчийн формат болон стандартын дэлгэрэнгүй мэдээлэл;

(10) дараах шаардлагатай холбоотой хүсэлт гаргагчийн журмын дэлгэрэнгүй:
   (i) ажилтны ур чадвар;
   (ii) баримт бичгийн хяналт;
   (iii) мэдээлэл цуглуулах;
   (iv) нисэхийн мэдээллийг хэвлэн нийтлэх;
   (v) хэвлэн нийтэлсэн мэдээллийн алдааг залруулах;
   (vi) бүртгэлийг таньж тогтоох, цуглуулах, индексжүүлэх, хадгалах, арчлах болон устгах;

(11) Ерөнхий зааврыг хянах, нэмэлт өөрчлөлт оруулах болон түгээх журам.

(b) Хүсэлт гаргагчийн Ерөнхий заавар нь Даргын хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой.

# С Бүлэг - Үйл ажиллагааны шаардлага

## 175.101. Байнгын хэрэгжилт

НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй ~~на~~:

(1) хүсэлт гаргагчийн Ерөнхий зааварт~~аа~~ заасан ажлын байрлал тус бүрд, тухайн зааврын нэгээс доошгүй хүчинтэй, бүрэн хувийг хадгалдаг байх;

(2) Ерөнхий заавартаа заасан бүх журам, стандартыг дагаж мөрддөг байх;

(3) Ерөнхий зааврын холбогдох бүлэг бүрийг шаардлагатай ажилтан ажил үүргээ гүйцэтгэхэд ашиглах боломжтой байлгах;

(4) энэ Дүрмийн дагуу гэрчилгээжүүлэлтэд тогтоосон В Бүлгийн шаардлага болон стандартыг байнга хангадаг байх;

(5) CAA 24175/01 маягтад шаардсан үйлчилгээ эрхлэх хаяг, утасны дугаар, эсхүл факсын дугаарын аливаа өөрчлөлтийг тухайн өөрчлөлт орсноос хойш 28 хоногийн дотор Даргад мэдэгддэг байх.

## 175.103. AIP-ын үйлчилгээ

(a) AIP-ын үйлчилгээ үзүүлдэг НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах мэдээллийг хэвлэн нийтлэх үүрэгтэй:

(1) D Бүлгийн дагуу Монгол Улсын AIP;

(2) 175.155-ын дагуу AIP-ын Өөрчлөлт;

(3) 175.157-гийн дагуу AIP-ын Нэмэлтээр дараах мэдээллийг:
   (i) 3 сар, эсхүл түүнээс урт хугацаатай түр өөрчлөлт;
   (ii) их хэмжээний текст, эсхүл графикийг багтаасан, 3 сараас бага хугацаатай мэдээлэл;

(4) Е Бүлгийн дагуу AIC;

(9) details of the applicant's format and standards required by rule 175.57(a)(1) for their published aeronautical information; and

(10) details of the applicant's procedures regarding-
  (i) the competence of personnel; and
  (ii) the control of documentation; and
  (iii) the collection of information; and
  (iv) the publication of aeronautical information; and
  (v) the correction of errors in published information; and
  (vi) the identification, collection, indexing, storage, maintenance, and disposal of records; and

(11) procedures to control, amend and distribute the exposition.

(b) The applicant's exposition must be acceptable to the Director.

## Subpart C - Operating Requirements

### 175.101. Continued compliance

~~Each~~ A holder of an aeronautical information service certificate ~~shall~~ must-

(1) hold at least one complete and current copy of ~~their~~ the holder's exposition at each office listed in ~~their~~ the exposition; and

(2) comply with all procedures and standards detailed in their exposition; and

(3) make each applicable part of ~~their~~ the exposition available to personnel who require those parts to carry out their duties; and

(4) continue to meet the standards and comply with the requirements of Subpart B prescribed for certification under this Part; and

(5) notify the Director of any change of address for service, telephone number, or facsimile number required by form CAA 24175/01 within 28 days of the change.

### 175.103. AIP service

(a) The holder of the aeronautical information service certificate for the AIP service must publish-

(1) the AIP Mongolia in accordance with Subpart D; and

(2) AIP Amendments in accordance with rule 175.155; and

(3) AIP Supplements in accordance with rule 175.157 for notification of-
  (i) temporary changes that are effective for 3 months or longer; and
  (ii) information of less than 3 months duration which contains extensive text or graphics; and

(4) the AIC in accordance with subpart E.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (a)-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байх үүрэгтэй:

(1) бусад улсын НМҮБ-тай Монгол Улсыг төлөөлөн харилцаж NOTAM-аас бусад Нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүнийг ~~нэгдсэн багцыг~~ харилцан солилцох нэгжийг томилох;

(2) тухайн мэдээллээр хангахтай холбоотой гарч болох төлбөрийг хийсний дараа Монгол Улсын AIP, AIP-ын Өөрчлөлт, AIP-ын Нэмэлт болон AIC-ыг аливаа этгээд ашиглах боломжтой байлгах;

(3) 175.61(c)(3)-ын дагуу Монгол Улсын AIP, AIP-ын Өөрчлөлт, AIP-ын Нэмэлт, нислэгийн зураг болон AIC-ыг түгээх тогтолцоог бүрдүүлэх;

(4) Монгол Улсын AIP-ын хэсгээр хэвлэн нийтлэгдсэн нислэгийн зураг бүрийг нислэгийн зургийн холбогдох стандартад нийцэж байгааг бататгах;

(5) дараахаас бусад тохиолдолд, 175.59(b)(1)-д заасан мэдээлэгч байгууллагаас ирсэн бүх нисэхийн мэдээлэлд зохицуулалт хийх:

(i) NOTAM гаргахыг яаралтай шаардсан, үйл ажиллагааны хойшлуулшгүй чухал ач холбогдолтой мэдээлэл;

(ii) зөвхөн NOTAM гаргахыг шаарддаг, 3 сараас бага хугацаатай түр мэдээлэл.

## 175.105. NOTAM-ын үйлчилгээ

NOTAM-ын үйлчилгээ үзүүлдэг НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) Монгол Улсын олон улсын NOTAM-ын нэгжийг томилох;

(2) олон улсын NOTAM-ын нэгжийг 24 цагаар ажиллуулах;

(3) NOTAM солилцох зорилгоор, олон улсын бусад NOTAM-ын нэгжтэй гэрээ байгуулах;

(4) дараах шаардлагыг бататгах:

(i) олон улсын NOTAM-ын нэгж нь AFS-нд холбогдсон байх;

(ii) AFS-ийн холболт нь хэвлэлийн өгөгдөл дамжуулах (printed communication) чадвартай байх;

(iii) олон улсын NOTAM-ын нэгж нь холбоогоор түгээгддэг NOTAM хүлээн авах болон гаргах чадвартай байгууламжтай байх;

(5) 175.59-ийн дагуу хүлээн авсан мэдээллээр NOTAM гаргах шаардлагатай тохиолдолд, F Бүлгийн дагуу түргэн шуурхай NOTAM гаргана;

(6) AFS-ээр дамжуулан, хүчинтэй байгаа NOTAM-ын шалгах хуудсыг 1 сараас ихгүй үечлэлтэй байхаар гаргана.

## 175.107. Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ

(a) Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь нислэгийн үйл ажиллагааны ажилтан болон нисэх багийн гишүүнийг дараах нисэхийн мэдээллийг авч хэрэглэх боломжоор хангах үүрэгтэй:

(1) агаарын навигацийн аюулгүй байдал, тогтмолжилт болон үр дүнд зайлшгүй шаардлагатай;

(b) The certificate holder must, in addition to paragraph (a)-

(1) designate an office as Mongolian's point of contact with the aeronautical information services of other States for the interchange of the ~~Integrated~~ Aeronautical Information Product ~~Package~~, except NOTAM; and

(2) make the AIP Mongolia, AIP Amendments, AIP Supplements and AIC available to any person upon payment of a charge that may apply to the supply of the publications; and

(3) establish a system to disseminate the AIP Mongolia, AIP Amendments, AIP Supplements, aeronautical charts, and AIC in accordance with rule 175.61(c)(3); and

(4) ensure that every aeronautical chart published as part of the AIP Mongolia conforms to the applicable standards for the charts; and

(5) coordinate the input of all aeronautical information from the originators prescribed in rule 175.59(b)(1), except-

(i) information which is of immediate operational significance necessitating the immediate issue of a NOTAM; and

(ii) temporary information of a duration of less than 3 months, that only requires the issue of a NOTAM.

## 175.105. NOTAM Service

The holder of the aeronautical information service certificate for the NOTAM service shall-

(1) designate an international NOTAM office for Mongolia; and

(2) operate the international NOTAM office on a 24-hour basis; and

(3) establish agreements with other international NOTAM offices for the exchange of NOTAM; and

(4) ensure that-

(i) the international NOTAM office is connected to the AFS; and

(ii) the AFS connection provides for printed communication; and

(iii) the international NOTAM office has appropriate facilities to issue and receive NOTAM distributed by means of telecommunication; and

(5) promptly issue a NOTAM that is in accordance with Subpart F, whenever information received under 175.59 requires the issue of a NOTAM; and

(6) at intervals of not more than one month, issue a checklist over the AFS of the NOTAM that are currently in force.

## 175.107. Pre-flight information service

(a) A holder of an aeronautical information service certificate for a pre-flight information service must make available to flight operations personnel and flight crew members, aeronautical information that-

(1) is essential for the safety, regularity and efficiency of air navigation; and

(2) гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт заасан газарзүйн бүс, аэродром болон агаарын замтай холбоотой.

(b) Энэ зүйлийн (a)-ийн дагуу хангадаг нисэхийн мэдээлэл нь хамааралтай бол дараах мэдээллийг багтаасан байх ёстой:

(1) хүчинтэй NOTAM-ын дэлгэрэнгүй болон яаралтай бусад мэдээллийг PIB-д текст хэлбэрээр;

(2) нисэхийн мэдээллийн бүтээгдэхүүний ~~нэгдсэн багцын~~ холбогдох элемент;

(3) холбогдох газрын зураг болон нислэгийн зураг;

(4) дараах хүчин зүйлийн талаарх нисэн гарах аэродромд хамааралтай хүчинтэй мэдээлэл:

(i) маневрын талбайд, эсхүл түүний ойролцоох барилгын, эсхүл засварын ажил;

(ii) ХБЗ болон явгалах замын гадаргуугийн эвдэрсэн хэсгийг багтаасан тэмдэглэгээтэй, эсхүл тэмдэглэгээгүй маневрын талбайн тэгш бус хэсэг;

(iii) гадаргуугийн барьцалтад үзүүлэх нөлөөг багтаасан, ХБЗ болон явгалах зам дээр цас, мөс, эсхүл ус байх ба тэдгээрийн зузаан;

(iv) ХБЗ, эсхүл явгалах зам дээр, эсхүл түүний хажууд хунгарласан, эсхүл овоолсон цас;

(v) явгалах зам дээр, эсхүл түүний хажууд байгаа агаарын хөлөг, эсхүл бусад объект;

(vi) шувууг багтаасан бусад түр шинжтэй аюултай нөхцөл байх;

(vii) ойртолт, босго, ХБЗ, явгалах зам, саадын болон маневрын талбайн ажиллагаагүй хэсгийн гэрэл, аэродромын цахилгаан тэжээлийг багтаасан аэродромын гэрэлтүүлгийн системийн хэсэгчилсэн, эсхүл бүрэн ажиллагаагүй байдал, эсхүл хэвийн бус ажиллагаа;

(viii) ILS болон маркер, PSR, SSR, VOR, NDB, VHF аэромобил суваг, RVR ажиглалтын систем болон нөөц цахилгаан хангамжийг багтаасан агаарын навигацийн байгууламжийн үйл ажиллагааны төлөв байдалд гарсан өөрчлөлт, эсхүл ажиллагаагүй байдал, хэвийн бус ажиллагаа;

(c) Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий заавартаа заасан аэродромд нислэгийн дараах мэдээллийг мэдээлэх боломжоор нисэх багийн гишүүдийг хангах үүрэгтэй.

(d) Нислэгийн өмнөх мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь агаарын навигацийн байгууламжийн нөхцөл байдал болон үйл ажиллагаатай холбоотой, энэ зүйлийн (c)-гийн дагуу нисэх багийн гишүүдийн мэдээлсэн нислэгийн дараах мэдээллийг тухайн агаарын навигацийн байгууламжийн үйл ажиллагаа эрхлэгчид дамжуулах үүрэгтэй.

(2) relates to the geographic area, aerodromes and air routes listed in the certificate holder's exposition.

(b) The aeronautical information provided under paragraph (a) must include, where applicable-

(1) a summary of current NOTAM and other information of an urgent character, in a plain text PIB; and

(2) relevant elements of the ~~integrated~~ aeronautical information product ~~package~~; and

(3) relevant maps and charts; and

(4) current information relating to the aerodrome of departure concerning any of the following:

(i) construction or maintenance work on or immediately next to the manoeuvring area:

(ii) rough portions of any part of the manoeuvring area, whether marked or not, including broken parts of the surface of runways and taxiways:

(iii) presence and depth of snow, ice, or water on runways and taxiways, including their effect on surface friction:

(iv) snow, drifted or piled on or next to runways or taxiways:

(v) parked aircraft or other objects on or immediately next to taxiways:

(vi) the presence of other temporary hazards including those created by birds:

(vii) failure or irregular operation of part or all of the aerodrome lighting system including approach, threshold, runway, taxiway, and obstruction lights, and manoeuvring area unserviceability lights, and aerodrome power supply:

(viii) failure, irregular operation or changes in the operational status of air navigation facilities including ILS and markers, PSR, SSR, VOR, NDB, VHF aeromobile channels, RVR observing system, and secondary power supply.

(c) The holder of an aeronautical information service certificate for a pre-flight information service must ~~make provision~~ provide for flight crew members to report post-flight information at those aerodromes listed in the certificate holder's exposition.

(d) The holder of an aeronautical information service certificate for a pre-flight information service must forward any post-flight information reported by flight crew members under paragraph (c) concerning the state and operation of air navigation facilities, to the operator of the navigation facility.

### 175.109. Гэрчилгээ эзэмшигчийн байгууллагын өөрчлөлт

(a) НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлтийг тухайн байгууллага болон үйлчилгээний тодорхойлолт хүчинтэй хэвээр хадгалагдаж байхаар хийдэг болохыг бататгах үүрэгтэй.

(b) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий зааврын нэмэлт өөрчлөлтийг энэ Дүрмийн холбогдох шаардлагад нийцэж байгаа ба Ерөнхий заавартаа заасан нэмэлт өөрчлөлт оруулах журмыг дагаж мөрдөж байгааг бататгах үүрэгтэй.

(c) Гэрчилгээ эзэмшигч нь Ерөнхий заавартаа нэмэлт өөрчлөлт оруулсны дараа тухайн зааврын нэмэлт өөрчлөлтийн хувийг Даргын хэрэгцээнд зориулж цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.

(d) Гэрчилгээ эзэмшигч нь дараах өөрчлөлтийг хийхийн өмнө Даргын зөвшөөрлийг урьдчилан авах шаардлагатай:

(1) Гүйцэтгэх захирал;

(2) жагсаалтад заасан удирдах ажилтнууд;

(3) гэрчилгээ эзэмшигчийн үзүүлдэг НМҮ;

(4) гэрчилгээний эрхийн хүрээнд хэвлэн нийтлэх нисэхийн мэдээллийн формат болон стандарт;

(5) аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, хэрэв тухайн өөрчлөлт нь бодит өөрчлөлт бол.

(e) Энэ зүйлийн (d)-д заасан өөрчлөлтийг хийж байх үед, эсхүл түүнийг хийсний дараа тухайн гэрчилгээ эзэмшигчийн дагаж мөрдөх ёстой нөхцөлийг Дарга тогтоож болно.

(f) Гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (e)-гийн дагуу Даргын тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөх үүрэгтэй.

(g) Хэрэв энэ зүйлд заасан өөрчлөлт нь гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж байгаа бол, гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг баталгаажуулсан тэмдэглэл хийлгэхээр Даргад цаг алдалгүй хүргүүлэх үүрэгтэй.

(h) Нисэхийн аюулгүй байдлын ашиг сонирхол шаардлагатай гэж Даргын үзсэн нэмэлт өөрчлөлтийг гэрчилгээ эзэмшигч нь, Ерөнхий заавартаа оруулна.

## 175.109. Changes to certificate holder's organisation

(a) A holder of an aeronautical information service certificate must ensure that the holder's exposition is amended so as to remain a current description of the holder's organisation and services.

(b) The certificate holder must ensure that any amendment made to its exposition meets the applicable requirements of this Part and complies with the amendment procedures contained in its exposition.

(c) The certificate holder must forward to the Director for retention a copy of each amendment to its exposition as soon as practicable after the amendment is incorporated into its exposition; and

(d) Before a certificate holder changes any of the following, prior acceptance by the Director is required:

- (1) the chief executive:
- (2) the listed senior persons:
- (3) the aeronautical information services provided by the holder:
- (4) the format and standards for the aeronautical information published under the authority of their certificate.
- (5) the system for safety management, if the change is a material change.

(e) The Director may impose conditions under which a certificate holder must operate during or following any of the changes specified in paragraph (d).

(f) A certificate holder must comply with any condition imposed by the Director under paragraph (e).

(g) If any change referred to in this rule requires an amendment to the certificate, the certificate holder must forward the certificate to the Director for endorsement of the change as soon as practicable.

(h) The certificate holder shall make such amendments to its exposition as the Director may consider necessary in the interests of aviation safety.

# D Бүлэг - Монгол Улсын AIP

## 175.151. Монгол Улсын AIP-ын агуулга

(a) Монгол Улсын AIP нь дараах үйлчилгээтэй холбоотой хүчинтэй мэдээлэл, өгөгдөл болон нислэгийн зургийг багтаасан байх ёстой:

(1) НХҮ-г Монгол Улс хариуцдаг, Монгол Улсын FIR-ийн агаарын навигацийн зохицуулалтын болон агаарын зайн шаардлага;

(2) Монгол Улсаас болон Монгол Улс руу үйлдэх олон улсын агаарын навигацид дэмжлэг үзүүлдэг Монгол Улсын үйлчилгээ болон байгууламж;

(3) Монгол Улсын FIR дэх агаарын навигацид дэмжлэг үзүүлдэг Монгол Улсын үйлчилгээ болон байгууламж;

(4) ИНД-139-ийн дагуу олгосон аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг аэродром.

(b) Монгол Улсын AIP нь аэродромын үйл ажиллагаа эрхлэгчийн гэрчилгээний эрхийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэггүй аэродромд хамаарах хүчинтэй мэдээлэл, өгөгдөл болон нислэгийн зургийг багтааж болно, хэрэв:

(1) аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь AIP-ын үйлчилгээ үзүүлдэг НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийг тухайн аэродромд хамаарах шаардлагатай өгөгдөл болон мэдээллээр хангадаг бол;

(2) аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь тухайн өгөгдөл болон мэдээллийн нарийвчлал, хүчинтэй байдлыг хариуцахаа хүлээн зөвшөөрсөн бол;

(c) Монгол Улсын AIP нь холбогдох хэсэгтээ дараах мэдээллийг багтаасан байх ёстой:

(1) Монгол Улсын AIP-д орсон агаарын навигацийн байгууламж, үйлчилгээ болон журмыг хариуцсан, гэрчилгээжсэн байгууллагын талаар зөвлөгөө өгөх мэдэгдэл;

(2) тухайн үйлчилгээ болон байгууламжийг ашиглахад шаардлагатай ерөнхий нөхцөл;

(3) Конвенцийн Зүйл 38-ын дагуу Даргын гаргасан, ~~журам болон~~ ICAO-гийн стандарт, зөвлөмж~~ийн~~ болон журмын зөрүүтэй шаардлагын жагсаалт;

(4) ICAO-гийн стандарт, зөвлөмж болон журамд өөр аргаар хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн үйл ажиллагаа байгаа бол, Монгол Улсад мөрдөж байгаа чухал ач холбогдолтой стандарт, зөвлөмж болон журмын хураангуй.

## 175.153. Монгол Улсын AIP-ын тодорхойлолт

(a) Монгол Улсын AIP-ын хэсгийг бүрдүүлж байгаа ~~мэдээлэл~~ хэвлэл нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

(1) тухайн ~~мэдээлл~~ хэвлэлийн зорилго, хамрах газарзүйн бүс болон тухайн ~~мэдээлэл~~ хэвлэл Монгол Улсын AIP-ын хэсэг болохыг заадаг байх;

(2) ойлгомжтой дугаарласан, хуудасны дугаартай гарчгийг багтаасан бие даасан байх;

# Subpart D - Aeronautical Information Publication Mongolia

## 175.151. Contents of AIP Mongolia

(a) The AIP Mongolia must contain current information, data and aeronautical charts relating to-

(1) the regulatory and airspace requirements for air navigation in the Mongolian FIR in which Mongolia is responsible for air traffic services; and

(2) the Mongolian services and facilities that support international air navigation to and from Mongolia; and

(3) the services and facilities that support air navigation within the Mongolian FIR; and

(4) aerodromes operating under an aerodrome operating certificate issued in accordance with Part 139.

(b) The AIP Mongolia may contain current information, data, and aeronautical charts relating to aerodromes not operating under an aerodrome operating certificate, if-

(1) the aerodrome operator provides the holder of the aeronautical information service certificate for the AIP service with the required data and information relating to the aerodrome; and

(2) the aerodrome operator accepts responsibility for the accuracy and currency of that data and information.

(c) The AIP Mongolia must include at an appropriate location-

(1) a statement to advise which certificated organisations are responsible for the air navigation facilities, services and procedures covered by the AIP Mongolia; and

(2) the general conditions under which those services and facilities are available for use; and

(3) a list of the differences with the ICAO Standards, Recommended Practices and Procedures that the Director has filed under Article 38 of the Convention; and

(4) a summary of any significant standards, practices and procedures followed by Mongolia, where the ICAO Standards, Recommended Practices and Procedures allow alternative courses of action.

## 175.153. Specifications for AIP Mongolia

(a) Each publication that forms part of the AIP Mongolia must-

(1) specify the purpose of the publication, the geographic area covered and that the publication is part of the AIP Mongolia ; and

(2) be self-contained, include a table of contents with page numbers, and be paginated clearly; and

(3) дараах этгээд хэвлэн нийтэлснийг заадаг байх:
  (i) AIP-ын үйлчилгээ үзүүлдэг НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч;
  (ii) Даргын олгосон гэрчилгээний эрхийн хүрээнд;
(4) шаардлагагүй байдлаар тухайн мэдээллийг давтахгүй байх ба хэрэв давтах шаардлагатай бол, ижил байгууламж, үйлчилгээ, эсхүл журмын хувьд тухайн давтсан мэдээлэл нь хоорондоо зөрүүгүй байх ёстой;
(5) хугацаатай байх, эсхүл хэрэв тухайн хэвлэлийн хуудас нь салдаг бол, хуудас бүр нь хугацаатай байх ёстой. Хугацаа нь тухайн нисэхийн мэдээлэл хүчинтэй болох өдрийг тоогоор, сарыг үсгээр, жилийг тоогоор заасан байх ёстой.
(6) AIP-ын Өөрчлөлтөөр, эсхүл тогтмол үечлэлтэй дахин гардаг байх;
(7) бататгаагүй мэдээллийн үнэн зөв байх магадлалын түвшнийг тодорхой заасан байх.

(b) Хуудас нь салдаг хэлбэрээр хэвлэ~~н нийтэл~~сэн ~~мэдээлэл~~ хэвлэл нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:
(1) хуудас бүрд, тухайн ~~мэдээлэл~~ хэвлэл хамаарах хуудас болон тухайн хуудас нь Монгол Улсын AIP-ын хэсэг болохыг заасан байх;
(2) дараах шалгах хуудсыг багтаасан байх:
  (i) тухайн ~~мэдээлэл~~ хэвлэлд багтсан хуудас, эсхүл нислэгийн зураг бүрийн хүчинтэй хугацаа болон хуудасны дугаар, эсхүл зургийн нэрийг заадаг;
  (ii) AIP-ын Өөрчлөлттэй хамт гардаг;
  (iii) аль ~~мэдээлэл~~ хэвлэлд хамаарахыг заадаг;
  (iv) энэ зүйлийн (a)(5)-д заасан хуудасны дугаар болон хугацаатай хэвлэгддэг.

## 175.155. AIP-ын Өөрчлөлтийн тодорхойлолт

AIP-ын Өөрчлөлт нь дараах шаардлагыг хангасан байна:
(1) хэвлэн нийтэлсэн мэдээлэлд орсон бүх өөрчлөлт болон дахин хэвлэсэн хуудсанд орсон бүх шинэ мэдээлэл нь ялгах тэмдэг, эсхүл тэмдэглэгээгээр тодорхой танигддаг байх;
(2) хуанлийн жилд үндэслэсэн, дараалсан серийн дугаартай байх.

## 175.157. AIP-ын Нэмэлтийн тодорхойлолт

(a) AIP-ын Нэмэлтэд тухайн хуанлийн жилд үндэслэн, дараалсан серийн дугаар олгодог байх ёстой.

(b) AIP-ын Нэмэлтийн хуудас нь, түүний аль нэг агуулга хүчинтэй байгаа бол Монгол Улсын AIP-ын хүчинтэй хэсэг хэвээр байх ёстой.

(c) Хүчинтэй AIP-ын Нэмэлтийн шалгах хуудсыг ~~AIP-ын Нэмэлттэй хамт, эсхүл~~ нэг сараас хэтрэхгүй үечлэлтэй гаргах ёстой.

(d) Шалгах хуудсыг тухайн AIP-ын Нэмэлтийг түгээсэн ижил хаягаар хүргүүлэх ёстой.

(3) specify that it is published-
  (i) by the holder of the aeronautical information service certificate for the AIP service; and
  (ii) under the authority of the holder's certificate issued by the Director; and
(4) not duplicate information unnecessarily and if duplication is necessary, there must be no difference in the duplicated information in respect of the same facility, service or procedure; and
(5) be dated, or if the publication is in loose-leaf form, each page must be dated. The date must consist of the day, month by name, and the year when the aeronautical information becomes effective; and
(6) be updated by means of AIP Amendments or by reissue at regular intervals; and
(7) show clearly the degree of reliability of any unverified information.

(b) A publication published in loose-leaf form must-
(1) specify on each page, which publication the page belongs to and that the page is part of the AIP Mongolia ; and
(2) contain a checklist that-
  (i) gives the current date, and page number or chart title of each page or chart in the publication; and
  (ii) is issued with each AIP Amendment; and
  (iii) specifies which publication it belongs to; and
  (iv) is printed with a page number and the date as prescribed in paragraph (a)(5).

## 175.155. Specifications for AIP Amendments

Each AIP Amendment shall-
(1) clearly identify, by a distinctive symbol or annotation, all changes to the published information, and all new information on a reprinted page; and
(2) be allocated a serial number, which shall be consecutive and based on the calendar year.

## 175.157. Specifications for AIP supplements

(a) Each AIP Supplement must be allocated a serial number which must be consecutive and based on the calendar year.

(b) The AIP Supplement pages must remain part of the AIP Mongolia while any part of their contents remain valid.

(c) A checklist of AIP Supplements currently in force must be issued ~~with each AIP Supplement or~~ at intervals of not more than one month.

(d) The checklist must be given the same distribution as the AIP supplement.

# E Бүлэг - AIC

## 175.201. AIC-ын тодорхойлолт

(a) AIC нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) хэвлэмэл, эсхүл цахим хэлбэрээр түгээгддэг байх;

(2) хуанлийн жилд үндэслэсэн, дараалсан серийн дугаартай байх.

(b) Олон улсад ~~ын~~ агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгчид хамаарах AIC-ыг AIP-тай адил түгээнэ.

(c) AIC-ыг нэгээс олон сериэр түгээх тохиолдолд, сери бүр нь эхний үсгээр тусдаа танигддаг байна.

(d) Хүчинтэй AIC-ын шалгах хуудсыг жилд нэгээс доошгүй удаа гаргах ба AIC-тай адил түгээнэ.

# F Бүлэг - NOTAM

## 175.251. NOTAM-ын тодорхойлолт

(a) NOTAM нь NOTAM-ын нэгжээс олгосон A, эсхүл B, эсхүл C серийн дугаартай байх ёстой. Серийн доторх серийн дугаар нь хуанлийн жилд үндэслэн, дараалсан байх ёстой.

(b) C серийн NOTAM нь дараах нисэхийн мэдээллийг багтаасан байх ёстой:

(1) Монгол Улсын FIR-д нислэг үйлдэж байгаа үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой;

(2) A, эсхүл B серийн NOTAM-д хэвлэн нийтлээгүй.

(c) A, эсхүл B серийн NOTAM нь Монгол Улсын FIR-д нислэг үйлдэж байгаа олон улсын үйл ажиллагаа эрхлэгчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдолтой нисэхийн мэдээллийг багтаасан байх ёстой.

(d) NOTAM нь товч, зөвхөн нэг сэдвийг хамарсан байх ба түүнд ~~ий утгыг~~ өөр баримт бичгийн ~~игт~~ ишлэл хийхгүйгээр тодорхой боловсруулагдсан байх ёстой.

(e) Хэрэв NOTAM нь Монгол Улсын AIP-д өөрчлөлт оруулах, эсхүл AIP-ын Нэмэлт гаргахыг шаардсан мэдээллийг агуулдаг бол, NOTAM нь хамаарах Монгол Улсын AIP~~-ын текст~~, эсхүл AIP-ын Нэмэлтийн ~~тэй холбоотой лавлагааг~~ харилцан-ишлэлийг (cross-reference) багтаасан байх ёстой.

(f) Хэрэв өмнөх NOTAM-ыг цуцалж, эсхүл сольж NOTAM гаргасан бол, өмнөх NOTAM-ын серийн дугаарыг заасан байх ёстой.

(g) Хэрэв NOTAM-д алдаа илэрсэн бол, тухайн NOTAM-ыг цуцал~~сан~~ж, шинэ NOTAM гаргах, эсхүл солих NOTAM-ыг гаргах ёстой.

(h) NOTAM-ын текстэд багтсан байршил заах код нь ICAO-гийн баталсан кодтой тохирч байх ёстой.

(i) Байршил заах кодыг хураангуйлсан хэлбэрээр ашиглаж болохгүй.

# Subpart E - AIC

## 175.201. Specifications for an AIC

(a) Each AIC shall-

(1) be issued in printed, or electronic form; and

(2) be allocated a serial number which should be consecutive and based on the calendar year.

(b) An AIC affecting international aircraft operators shall be given the same distribution as the AIP.

(c) Where AIC are distributed in more than one series, each series shall be separately identified by a prefix letter.

(d) A checklist of AIC currently in force shall be issued at least once a year and distributed as an AIC.

# Subpart F - NOTAM

## 175.251. Specifications for NOTAM

(a) Each NOTAM must be allocated a serial number by the NOTAM Office in either an A or B series or a C series. The serial number within each series must be consecutive and based on the calendar year.

(b) The C series of NOTAM must only contain aeronautical information that-

(1) is operationally significant to operators operating within the Mongolian FIR; and

(2) is not published in the A or B series of NOTAM.

(c) The A or B series of NOTAM must contain aeronautical information that is operationally significant to international operators operating in the Mongolian FIR.

(d) Each NOTAM must be brief, deal with only 1 subject, and be compiled so that its meaning is clear without reference to another document.

(e) If a NOTAM contains information that requires an amendment to the AIP Mongolia or an AIP Supplement, the NOTAM must contain a cross-reference to the affected AIP Mongolia text or AIP Supplement.

(f) If a NOTAM is issued which cancels or supersedes a previous NOTAM, the serial number of the previous NOTAM must be specified.

(g) If an error is detected in a NOTAM, a replacement NOTAM which cancels the original must be issued.

(h) Location indicators included in the text of a NOTAM must conform to those approved by ICAO.

(i) A curtailed form of location indicator must not be used.

(j) Хэрэв байршил заах кодыг тухайн байршилд олгоогүй бол, 175.61(b)(9)-ийн дагуу үсэглэн бичсэн тухайн газрын нэрийг NOTAM-ын текстэд оруулсан байх ёстой.

(k) Энэ дүрмийн 175.105(6)-д шаардсан NOTAM-ын шалгах хуудас нь дараах шаардлагыг хангасан байх ёстой:

(1) хамгийн сүүлчийн AIP-ын Өөрчлөлт, AIP-ын Нэмэлт болон олон улсад түгээсэн AIC-ыг д ишлэл хийсэн байх;

(2) шалгах хуудсанд ишлэл хийсэн тухайн серийн NOTAM-тай адил түгээгдэх ба шалгах хуудас гэж тодорхой тэмдэглэгдсэн байх.

(l) A, эсхүл B серийн NOTAM-ыг олон улсад түгээхэд тохиромжтой хэлбэрээр бэлтгэж боловсруулах ёстой.

## 175.253. NOTAM-ыг түгээх

(a) NOTAM нь дараах шаардлагыг хангасан байна:

(1) боломжтой бол, холбооны нэг мэдээгээр дамжуулдаг байх;

(2) тухайн мэдээлэл үйл ажиллагаанд нь шууд ач холбогдолтой, мөн тухайн мэдээллийг өөр хэлбэрээр авах боломжгүй этгээдэд 7-гоос доошгүй хоногийн өмнө мэдээг урьдчилсан мэдэгдлийг өөр хэлбэрээр авах боломжгүй этгээдэд түгээдэг байх.

(b) C серийн NOTAM-ыг Монгол Улс дотор түгээнэ.

(c) A, эсхүл B серийн NOTAM-ыг Монгол Улс дотор болон 175.105(3)-ын дагуу гэрээ байгуулсан олон улсын NOTAM-ын нэгжид түгээнэ.

(d) Боломжтой бүх тохиолдолд NOTAM түгээхэд AFS ашиглана.

(e) Энэ дүрмийн 175.105(3)-ын дагуу байгуулсан гэрээний хүрээнд солилцсон NOTAM-ыг AFS-ээс өөр хэрэгслээр илгээсэн тохиолдолд, тухайн NOTAM гаргасан цаг хугацааг харуулдаг өдөр-цаг хугацааны 6 оронтой тоо болон мэдээлэгч байгууллагын таних тэмдгийг NOTAM-ын текстийн урд бичнэ.

(f) Энэ дүрмийн 175.105(3)-ын дагуу бусад олон улсын NOTAM-ын нэгжтэй байгуулсан гэрээний хувьд, боломжтой бүх тохиолдолд, AFS-ээр дамжуулдаг NOTAM-ын урьдчилан тогтоосон түгээлтийн системийг ашигладаг байна.

(j) If no location indicator is assigned to the location, the name of the place, spelt in accordance with rule 175.61(b)(9), must be entered in the text of the NOTAM.

(k) The NOTAM checklist required under rule 175.105(6) must-

(1) refer to the latest AIP Amendments, AIP Supplements and the internationally distributed AIC; and

(2) have the same distribution as the actual NOTAM series to which the checklist refers and must be clearly identified as a checklist.

(l) Each NOTAM in the A or B series must be prepared and composed in a manner suitable for international distribution.

## 175.253. Distribution of NOTAM

(a) Each NOTAM shall-

(1) ~~where possible,~~ be transmitted as a single telecommunication message; and

(2) be distributed to addressees to whom the information is of direct operational significance, and who would not otherwise have ~~at least seven days~~ prior notification.

(b) The C series of NOTAM shall be distributed within Mongolia.

(c) The A or B series of NOTAM shall be distributed within Mongolia and to those international NOTAM offices with whom agreements have been established under 175.105(3).

(d) The AFS shall be employed for NOTAM distribution, whenever practicable.

(e) When a NOTAM exchanged under the agreement established under 175.105(3), is sent by means other than the AFS, a six-digit date-time group indicating the date and time of filing the NOTAM and the identification of the originator shall precede the text of the NOTAM.

(f) A predetermined distribution system for NOTAM transmitted on the AFS shall be used, whenever possible, subject to the agreements established under 175.105(3) with other international NOTAM offices.

# G Бүлэг - Шилжилтийн зохицуулалт

## 175.301. НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн шилжилт

(a) Энэ зүйл нь дараах этгээдэд хамаарна:

(1) НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч;

(2) НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч.

(b) Энэ зүйлд хамаарах байгууллага нь, энэ зүйлийн (e)(2)-ын дагуу тогтоосон хэрэгжүүлэлтийн хугацаанаас өмнө дараах заалтыг мөрдөх шаардлагагүй:

(1) 175.51(a)(2)(ii), хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо хариуцсан удирдах ажилтны оронд дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтантай бол;

(2) 17~~1~~5.67, хэрэв байгууллага нь аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх болон мөрдөхийн оронд 17~~1~~5.303-ыг хангасан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн бол;

(3) 175.69(a)(1A)(i);

(4) 175.69(a)(3)(ii);

(5) 175.69(a)(5A).

(c) НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч болон НМҮБ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч нь гүйцэд бөглөсөн CAA маягт болон хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг 2022~~1~~ оны 9 ~~4~~ сарын 30 ~~1~~-нээс өмнө Даргад хүргүүлэх үүрэгтэй.

(d) Энэ зүйлийн (c)-д заасан хэрэгжүүлэлтийн төлөвлөгөө нь дараах шаардлага хангасан байх ёстой:

(1) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн санал болгосон хугацааг багтаасан байх;

(2) тухайн байгууллага 175.67-д шаардсан аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог хэрхэн хэрэгжүүлэх төлөвлөгөөг дүрслэн харуулсан байх.

(e) Хэрэв хүлээн зөвшөөрөхүйц бол, Дарга:

(1) тухайн байгууллагын хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг батална;

(2) аюулгүй байдлын удирдлагын тогтолцооны хэрэгжүүлэлтийн хугацааг тогтооно.

(f) Энэ зүйлийн (e)(2)-ын дагуу хугацааг тогтоохдоо, Дарга дараах нөхцөлийг тооцох үүрэгтэй:

(1) тухайн байгууллагын хүчин чадал;

(2) тухайн байгууллагын төвөгшил;

(3) тухайн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой эрсдэл;

(4) гэрчилгээг сунгах хугацаа;

(5) тухайн байгууллага, эсхүл ИНЕГ, эсхүл хоёуланд нь хамаарах эх үүсвэр, эсхүл хуваарийн нөлөө;

(6) хэрэгжүүлэлтийн хугацаа нь 2023~~2~~ оны 2 сарын 1-нээс хойш байж болохгүй.

# Subpart G - Transition Provisions

## 175.301. Transition for aeronautical information service certificate holders

(a) This rule applies to each-

(1) holder of an aeronautical information service certificate:

(2) applicant for the grant of an aeronautical information service certificate.

(b) Before the date for implementation set in accordance with subparagraph (e)(2), an organisation to which this rule applies is not required to comply with-

(1) rule 175.51(a)(2)(ii), if instead of a senior person responsible for the system for safety management, the organisation has a senior person responsible for internal quality assurance:

(2) rule 175.67, if instead of establishing, implementing, and maintaining the system for safety management, the organisation has established an internal quality assurance system that complies with rule 175.303:

(3) rule 175.69(a)(1A)(i):

(4) rule 175.69(a)(3)(ii):

(5) rule 175.69(a)(5A).

(c) A holder of an aeronautical information service certificate and an applicant for the grant of an aeronautical information service certificate must submit a completed CAA form and implementation plan to the Director by 30.Sep.2022.

(d) The implementation plan referred to in paragraph (c) must-

(1) include a proposed date for implementation of the system for safety management; and

(2) outline how the organisation plans to implement the system for safety management required under rule 175.67.

(e) The Director will, if acceptable-

(1) approve the organisation’s implementation plan; and

(2) set the date for implementation of the system for safety management.

(f) In setting the date under subparagraph (e)(2), the Director must have regard to the following:

(1) the capability of the organisation:

(2) the complexity of the organisation:

(3) the risks inherent in the activities of the organisation:

(4) the date of any certificate renewal:

(5) any resource or scheduling impacts on the organisation or the Authority or both:

(6) the date for implementation must not be later than 1.Feb.2023.

(g) Энэ зүйлийн (a)(1)-ийн дагуу НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээ сунгуулах хүсэлтэд хэрэгжүүлэлтийн төлөвлөгөөг хавсаргахгүй байж болно.

(h) Энэ зүйл нь 2023~~2~~ оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

### 175.303. НМҮБ-ын гэрчилгээ эзэмшигчийн шилжилтийн дотоод чанар баталгаажуулалт

Энэ Дүрмээр шаардсан журам нь дүрмийн шаардлага хангасан ба тухайн байгууллага түүнийг хэрэгжүүлж байгааг бататгах зорилгоор 171.301(b)~~(1)(ii)~~(2)-т шаардсан дотоод чанар баталгаажуулалтын тогтолцоог бүрдүүлсэн байх ёстой.

(a) Тухайн журамд дараах шаардлагыг багтаасан байх ёстой:

(1) хүсэлт гаргагчийн хүрэхээр зорьж байгаа чанарын түвшин;

(2) дотоод дүгнэлт хийх түвшин болон давтамж;

(3) дотоод дүгнэлт хариуцсан ажилтан, эсхүл ажилтнууд;

(4) дотоод дүгнэлтээр илэрсэн дутагдлыг хэрхэн бүртгэх болон Гүйцэтгэх захиралд мэдэгдэх;

(5) алдааны тайлан, зөрчил болон гомдол зэрэг чанарын үзүүлэлтийг дотоод чанар баталгаажуулалтын журамд хэрхэн оруулах;

(6) дотоод дүгнэлтэд дүн шинжилгээ болон үнэлгээ хийх удирдах ажилтны үүрэг хариуцлага;

(7) дотоод дүгнэлтийн үед илэрсэн аливаа дутагдлыг залруулах аргачлал;

(8) тухайн дүгнэлтийн талаар баримт бичиг бүрдүүлэх шаардлага.

(b) Дотоод чанар баталгаажуулалт хариуцсан удирдах ажилтан нь хэвлэн нийтэлсэн нисэхийн мэдээллийн нийцэл, нарийвчлал, цаг хугацаа, формат болон түгээлтэд нөлөөлөх асуудлаар Гүйцэтгэх захиралтай шууд харьцдаг байх үүрэгтэй.

(c) Энэ зүйл нь 2023~~2~~ оны 2 сарын 1-нд хүчингүй болно.

--oOo--

(g) A holder of an aeronautical information service certificate under subparagraph (a)(1) does not have to submit an implementation plan with its certificate renewal application.

(h) This rule expires on 1.Feb.2023.

## 175.303. Transitional internal quality assurance for aeronautical information service certificate holders

The internal quality assurance system required by rule 175.301(b)~~(1)(ii)~~(2)must be established to ensure the organisation's compliance with, and the adequacy of, the procedures required by this Part.

(a) The procedures must specify-

- (1) the level of quality that the applicant intends to achieve; and
- (2) the level and frequency of internal reviews; and
- (3) the person or persons responsible for carrying out the internal reviews; and
- (4) how the findings of the internal reviews are to be recorded and reported to the chief executive; and
- (5) how quality indicators such as error reports, incidents, and complaints are incorporated into the internal quality assurance procedures; and
- (6) the senior person's responsibilities for analysis and overview of the internal reviews; and
- (7) the means for rectifying any deficiencies found during an internal review; and
- (8) the documentation requirements for all aspects of the review.

(b) The senior person who has the responsibility for internal quality assurance must have direct access to the chief executive on matters affecting the adequacy, accuracy, timeliness, format, and dissemination of the published aeronautical information.

(c) This rule expires on 1.Feb.2023.

--oOo--